



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

**“ДАМБАДАРЖАА ДЭД ТӨВ БАРИХ ТӨСӨЛ”-
ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103 /**

АГУУЛГА

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1
1.1	Ерөнхий мэдээлэл	1
1.2	2024 оны барилгын ажлын хэрэгжилтийн талаарх товч танилцуулга	2
1.2.1	Дамба дэд төвд хэрэгжих DARI-1, 2 төслийн мэдээлэл	2
1.2.2	ASKG-DA гэрээний багц: 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн төлөвлөлт	5
1.2.3	DAEC гэрээний багц: Цахилгаан, холбоо, интернэтийн шугам сүлжээ татах ажил ...	6
1.2.4	СЕР гэрээний дугаартай: 58-р сургууль болон 83-р ус түгээх байр орчмын тохижилтын ажил:	7
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ..	10
3	БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА.....	10
3.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл.....	10
3.2	Уур амьсгал	11
3.3	Агаарын чанар.....	11
3.4	Геологийн тогтоц ба геоморфологи.....	12
3.4.1	Геологийн тогтоц	12
3.4.2	Геоморфологийн нөхцөл	13
3.5	Гадаргын ус	13
3.5.1	Сэлбэ гол.....	14
3.6	Газрын доорх ус	14
3.7	Хөрсөн бүрхэвч	15
3.8	Ургамлан нөмрөг.....	16
3.9	Амьтны аймаг.....	16
3.10	Тусгай хамгаалалттай газар нутаг.....	17
3.11	Түүх, соёлын өв.....	17
4	ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	19
4.1.1	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	19
4.1.2	3.2 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга зүй.....	19
4.1.3	3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	24

5	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ.....	28
6	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
6.1	DARI-1 гэрээний дугаар бүхий барилгын багц ажлын хүрээнд 2024 онд бүтээн байгуулах дэд бүтцийн байгууламжууд:	30
6.2	DARI-2 гэрээний дугаар бүхий барилгын багц ажлын хүрээнд 2024 онд бүтээн байгуулах дэд бүтцийн байгууламжууд:	40
6.3	GWD гэрээний дугаартай Авто зам, цэвэр, бохир, дулааны шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажлын хөрсний усны түвшин доошлуулах дренажийн ажил	51
6.4	DAEC гэрээний дугаар бүхий барилгын багц ажлын хүрээнд 2024 онд хийгдэх дэд бүтцийн ажлууд:	55
6.5	ASKG-DA гэрээний дугаар барилгын багцад 2024 онд хийгдэх ажлууд:	64
6.6	СЕР гэрээний дугаартай тоглоомын талбайн тохижилтын ажил	73
7	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	78
7.1.1	Нөхөн сэргээлтийн нэгдсэн дүн	79
7.2	ASKG-DA гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг	79
7.2.1	240 хүүхдийн цэцэрлэгийн техникийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо.	79
7.3	DARI-1 гэрээний дугаартай Нэгдүгээр багц	79
7.3.1	DARI-1 гэрээний дугаартай Нэгдүгээр багцын техникийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо.	79
7.4	DARI-2 гэрээний дугаартай Хоёрдугаар багц.....	80
7.4.1	DARI-2 гэрээний дугаартай Хоёрдугаар багцын техникийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо.	80
7.5	DAEC гэрээний дугаартай Цахилгаан хангамж болон Холбоо харилцаа.....	80
7.5.1	DAEC гэрээний дугаартай Цахилгаан хангамж болон Холбоо харилцаа багцын техникийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо.	80
7.6	GWD гэрээний дугаартай хөрсний ус зайлуулах.....	80
7.7	СЕР гэрээний дугаартай Тоглоомын талбайн тохижилт төсөл	81
8	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	82
9	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	82
10	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	83
11	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	84
12	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	88

13	ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ).....	90
14	БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	97
15	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	98

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Төслийн байршил.....	1
Хүснэгт 1-2. Төслийн хүрээнд хийгдэх ажлын тоо хэмжээ.....	2
Хүснэгт 1-3. Дамбадаржаа дэд төвд 2024 оны барилгын ажлын явц.....	2
Хүснэгт 4-1. Дамбадаржаа дэд төвийн 2024 БОМТ-ний зардлын хураангуй	29
Хүснэгт 5-1. DARI-1 багцын 2024 онд хэрэгжүүлж ажиллах Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	30
Хүснэгт 5-2. DARI-2 багцын 2024 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	40
Хүснэгт 5-3. DAEC багцын 2024 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	55
Хүснэгт 5-4. ASKG-DA багцын 2024 онд хэрэгжүүлж ажиллах Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	64
Хүснэгт 6-1. Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	78
Хүснэгт 6-2. Нөхөн сэргээлтийн нэгдсэн дүн.....	79
Хүснэгт 8-1. Газар эзэмшлийн нөхцөл байдал	82
Хүснэгт 12-1. Лабораторийн шинжилгээний тариф.....	90
Хүснэгт 13-1 . БОМТ хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.	97
Хүснэгт 14-1. Удирдлага зохион байгуулалт, оролцогч талуудад мэдээлэл өгөх, тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээ.....	98



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-3. Төслийн талбайн байршил.....	1
Зураг 1-1. 2023 оны барилгын ажлын явц.....	3
Зураг 1-2. Дамбадаржаа дэд төвийн засаг захиргааны хил хязгаар	1
Зураг 1-13. Төлөвлөж буй цэцэрлэгийн ерөнхий төлөвлөлт.....	5
Зураг 3-1. Дамбадаржаа дэд төвийн байршил, Засаг захиргааны хил хязгаар	11
Зураг 3-2. Төслийн талбай орчмын геологи.....	12
Зураг 3-3. Судалгааны талбай орчмын гадаргын усан сүлжээ	13
Зураг 3-4. Төслийн талбай орчмын гидрогеологи	14
Зураг 3-5. Гэр хорооллын хашаа хоорондох гудамжны ургамалгүй, ерөнхий төрх байдал.....	16
Зураг 3-6. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд.....	17

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл


“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 2-р үе шатанд хамрагдах Дамбадаржаа дэд төв нь Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 70.7 га талбайг хамран оршино. Төсөлд хамрагдах нутаг дэвсгэр нь одоогийн байдлаар 1145 өрхийн 4,236 оршин суугчтай ба 1 га талбайд 69 хүн ногдож байгаа хэдий ч уг төсөл хэрэгжсэнээр 2030 онд 1973 өрх, 7105 хүн 17 блоконд оршин сууж 1 га-д ногдох хүн амын тоо 165 болон өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Төслийн талбайн байршил, засаг захиргааны хуваарийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1-1. Төслийн байршил

№	Дүүрэг	Хамрах хороод	Координатын солбицол
1	Сүхбаатар дүүрэг	16, 17, 18-р хороод	47° 58' 51.9" 106° 55' 56.1"

Төслийн хүрээнд хийхээр төлөвлөгдсөн дэд бүтцийг хөгжүүлэх ажлын тоо хэмжээг доорх хүснэгтэд чиглэл тус бүрээр нь хураангуйлан үзүүлэв.

Зураг 1-1. Төслийн талбайн байршил



Хүснэгт 1-2. Төслийн хүрээнд хийгдэх ажлын тоо хэмжээ


Багцын дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ
DARI-1	Авто зам	Урт: 1063 м, өргөн: 7 м
	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none"> Дулааны шугам Урт= 1141 м, диаметр (Ф150~350мм) Дулааны дэд станц: 3 байрлалд
	Цэвэр усан хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1044 м
	Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: Ф200~300мм, урт= 1817 м
	Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 863 м, өргөн 1-1.5 м
DARI-2	Авто зам	Урт: 1526 м, өргөн: 7 м
	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none"> Дулааны шугам Урт= 1453 м, диаметр (Ф150~350мм) Дулааны дэд станц: 4 байрлалд
	Цэвэр усан хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1360 м
	Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: D200~300мм, урт= 1214 м
	Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 522 м, өргөн 1-1.5 м
DAEC	Цахилгаан хангамж	Цахилгааны кабель шугам: урт= 3038 м, хүчин чадал 160-240 кВ.мм 10/0.4кВ хүчин чадалтай хаалттай дэд станц (ХТП) шинээр байгуулах: 6 байрлалд Хаалттай хуваарилах байгууламж шинээр байгуулах: хүчин чадал 10кВ, 1 байрлалд.
	Холбоо харилцаа	Холбооны төвийн барилга: 1 байрлалд, 1 давхар барилга Шилэн кабель: урт=3 км Холбооны шугам: урт 6.3 км, диаметр: 110мм
ASKG-DA	Хүүхдийн цэцэрлэг	792м2 талбай бүхий 2 давхар барилга, 150 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай
GWD	Үерийн хамгаалалт	Дамбадаржаагийн үерийн сувгийг тохижуулах: Урт 895м, өргөн 1.0-1.5м; Ус нэвтрүүлэх туннель, урт: 540м, өргөн 300-500 мм
СЕР	Тоглоомын талбайн тохижилт	58-р сургууль болон 83-р ус түгээх байр орчмын тоглоомын талбай орчны тохижилтын ажил хийгдэнэ.

Хүснэгт 1-3. Дамбадаржаа дэд төвд 2024 оны барилгын ажлын явц


Гэрээний дугаар	Бүтээн байгуулалтын ажлын тодорхойлолт	Байршил	2023 оны барилгын ажлын явц	2024 оны хийгдэх барилгын ажил	Барилгын ажлын явцын хувь	2024 онд барилгын ажил гүйцэтгэх байгууллагын нэр
ASKG-DA	Хүүхдийн цэцэрлэгийн барилга	СБД-ийн 16,17-р хороод	Барилгын ажил эхлээгүй	Барилгын ажил эхлэх	0	Голомт Констракшн ХХК
DARI-1	Авто зам, дэд бүтцийн шугам сүлжээ байгуулах ажлууд, 1-р хэсэг	СБД-ийн 16,17-р хороод		Үндсэн суурь ажил хийгдэнэ	20	Янчэнг Шингүо Констракшн Инженйринг ХХК
DARI-2	Авто зам, дэд бүтцийн шугам сүлжээ байгуулах ажлууд, 2-р хэсэг	СБД-ийн 16,17-р хороод		Үндсэн суурь ажил хийгдэнэ	10	

Гэрээний дугаар	Бүтээн байгуулалтын ажлын тодорхойлолт	Байршил	2023 оны барилгын ажлын явц	2024 оны хийгдэх барилгын ажил	Барилгын ажлын явцын хувь	2024 онд барилгын ажил гүйцэтгэх байгууллагын нэр
DAEC	Цахилгаан, холбоо, интернэтийн шугам сүлжээ татах ажлууд	СБД-ийн 16,17-р хороод	Барилгын ажил эхлээгүй	Барилгын ажил эхлэх	0	Монхас ХХК
GWD	Хөрсний ус зайлуулах дренажын ажил	СБД-ийн 16,17-р хороод	Барилгын ажил эхлээгүй	Барилгын ажлыг 2024 онд багтааж дуусгах	-	Янчэнг Шингүо Констракшн Инженйринг ХХК
DAFPE	Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажил	СБД-ийн 16,17-р хороод	2023 оны 11 дууссан.		100	JV of Newconstruction LLC and Tenuunkhas Sar LLC
СЕР	Тоглоомын талбайн тохижилт	СБД-ийн 17-р хороо	Барилгын ажил эхлээгүй	-	-	-

Зураг 1-2. 2023 оны барилгын ажлын явц



Зураг 1-3. Дамбадаржаа дэд төвийн засаг захиргааны хил хязгаар



1.2 2024 оны барилгын ажлын хэрэгжилтийн талаарх товч танилцуулга

1.2.1 Дамба дэд төвд хэрэгжих DARI-1, 2 төслийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл		
Ерөнхий мэдээлэл	Аж ахуй нэгжийн нэр:	“Янчен Шингуо Констракшн Инженеринг” ХХК
	Бүртгэлтэй хаяг:	Жансу муж Янчен хот Ше Яан дүүрэг Хадэ суурин Наньюан 2-27-2
	Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар:	Улсын бүртгэлийн дугаар: 320924000086159 Регистрийн дугаар: 9935924
	Хуулийн этгээд:	Шү Чангуо
	Аж ахуй нэгжийн хэлбэр:	ХХК /хувь хүн хөрөнгө оруулсан /
	Гэрчилгээний ангилал:	Хот төлөвлөлт, шугам сүлжээ дулааны дэд төв 3-р зэрэг, Авто замын байгууламж, замын гэрэлтүүлэг, замын бетон хийцийн тусгай гүйцэтгэл 3-р зэрэг
	Үйл ажиллагааны чиглэл:	Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.
	Дэд төвийн байршил	Төслийн хүрээнд явагдах салбар шугамын холболтын ажлууд нь Сүхбаатар дүүргийн 14-р хороо, Чингэлтэй дүүргийн 18-р хороодыг хамарна.
Дамба дэд төвд хэрэгжих DARI-1, 2 төслийн төлөвлөгөө	Авто замын төлөвлөлт	Дамбадаржаа дэд төв нь 7 буудал руу чиглэсэн төв зам, Дарь эхийн зам, Бэлх чиглэлийн зам гэсэн 3 үндсэн замын голд оршдог хэдий ч тус дэд төв дотор хатуу хучилттай авто замын сүлжээ байхгүй. Гэр хорооллын нарийн гудамжууд нь шороон замаар холбогдсон байдаг бөгөөд зарим хэсэгтээ машин зөрөх боломжгүй нарийхан буюу үзэгдэх орчин хязгаарлагдмал давчуу хэсгүүд ихтэй. Дамбадаржаа дэд төвийн авто замын сүлжээг сайжруулах зураг төслийг боловсруулахдаа Улаанбаатар хотын хөгжлийн Мастер төлөвлөгөөнд үндэслэн, тус дэд төвийн оршин суугчдаас гаргасан санал хүсэлтийг харгалзан боловсруулсан. Тус төслийн хүрээнд Дамбадаржаа дэд төвд Сэлбэ голын орчмоос Дамбадаржаалин хийд, Дамбадаржаагийн гүүр хүртэлх чиглэлд 2.589 км урттай хатуу хучилттай авто замыг шинээр барьж байгуулахаар төлөвлөсөн. Уг зам нь 6 хэсгээс бүрдэх бөгөөд тус дэд төвийн эргэн тойрон дахь төв замуудыг дэд төв доторх замын сүлжээтэй холбосон 3 уулзвартай байна. Авто замын өргөн нь 7 метр 2 эгнээ нийт 2.589 км урт байхаар төлөвлөгдсөн.
	Цэвэр усан хангамжын төлөвлөлт	Дамбадаржаа дэд төвийн цэвэр усан хангамж нь гүний усны эх үүсвэртэй бөгөөд 1–р үе шатны хүрээнд Сэлбэ дэд төвд барьж ашиглалтад оруулсан 1500 м3 багтаамжтай Хайлааст усан сан ба 1000 м3 багтаамжтай Дамбадаржаа усан сангаас тус тус хангагдана. Эдгээр усан сангуудыг Гачууртын эх үүсвэрээс хангах ба "Гачууртын эх үүсвэр" нь Улаанбаатар хотын иргэд, ялангуяа гэр хорооллын 390,000, орон сууцны 43,500 оршин суугчдыг цэвэр аюулгүй усаар хангагдах боломжийг бүрдүүлсэн томоохон эх үүсвэр юм. Энэ эх үүсвэр нь Улаанбаатараас 26 километрийн зайд, зүүн хэсэгт, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороонд оршдог. Нэг хоногт 25,200 м.куб усыг олборлон түгээх хүчин чадалтай. Одоогийн байдлаар өөрийн хүчин чадлын 40 хувиар ажиллаж байгаа тус дэд станц нь хоногт дунджаар манай хотын нийт ундны усны хэрэглээний 5-8 хувь буюу 8,000- 12,000 метр куб усыг олборлон иргэдэд хүргэж байна. "Гачуурт эх үүсвэр"-ийн ажиллах хүчин чадал: <ul style="list-style-type: none"> ○ Хоногт 25,200 метр куб усыг олборлоно, ○ 21 ширхэг гүний худагтай ○ Усан сангийн багтаамж 3000*2, ○ 700мм хүчитгэсэн шилэн доторлогоотой шинэ технологи бүхий 18,8 км ус дамжуулах шугам, ○ 5.5 км цуглуулах шугам, ○ Халдваргүйжүүлэх төхөөрөмж зэргийг тус тус суурилуулжээ.

		<p>Гачууртын эх үүсвэр нь олборлосон усыг Гачуурт усан санд хуримтлуулан ариутган цэвэршүүлсний дараа ф700 мм-ийн диаметр бүхий хоолойгоор дамжуулан Зүүн, хойд бүсийн усан санд нийлүүлж Хайлааст, Чингэлтэй, Долоон буудал, Дарь-Эх, Дамбадаржаа чиглэлийн гэр хорооллыг усаар хангах цаашид дээрх гэр хорооллуудад дахин төлөвлөлт хийж барилгажуулахад ундны усаар хангах томоохон ач холбогдолтой.</p>						
	<p>Ариутгах татуургын сүлжээний төлөвлөлт</p>	<p>Хөтөлбөрийн хүрээнд дэд төвүүдийн бохир усны шугам сүлжээ төвлөрсөн системд холбогдож, төв цэвэрлэх байгууламж руу холбогдохоор төлөвлөгдсөн. Түүнчлэн төв цэвэрлэх байгууламжийн бетон хийцийг сайжруулах, технологи шинэчлэлтийн ажлуудыг хийснээр дэд төвүүдээс холбогдох бохирыг хүлээж авах нөхцөл бүрдэх ба технологийн шинэчлэл нь цэвэрлэгээний чанарыг сайжруулах ач холбогдолтой. Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь нь амьдардаг гэр хорооллын ихэнх айлууд хашаан дотроо дунджаар 3-4 метрийн гүнтэй нүх ухаж 00-ийн зориулалтаар ашигладаг бөгөөд ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй байдаг. Иймд, гэр хороололд ашиглагддаг Нүхэн жорлон нь хөрсний бохирдлын томоохон эх үүсвэр болдог. Гэр хорооллын цөөн хэдэн айл болон албан газрууд нь бохирын септик ашигладаг бөгөөд дүүрмэгц нь соруулж зайлуулах байдлаар явдаг. Гэхдээ энэ нь харьцангуй өндөр өртөгтэй тул гэр хорооллын бүх айлд хэрэгжүүлэх боломжгүй юм. Тус төслийн 1-р үе шатны хүрээнд ариутгах татуургын сүлжээг Сэлбэ дэд төв хүртэл татсан бөгөөд 2-р үе шатны хүрээнд Сэлбэ дэд төвөөс цаашлуулан Дамбадаржаа дэд төв хүртэл шинээр 3.03 км урт бохир ус дамжуулах шугамыг барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Дамбадаржаа дэд төвөөс өдөрт 1540 м3 бохир ус цугларах ба түүнийг 200-300 мм-ийн диаметртэй уг шугамаар УБ хотын ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлнэ.</p>						
	<p>Дулаан хангамжын төлөвлөлт</p>	<p>Улаанбаатар хотын хүн амын 60% нь оршин суудаг гэр хороолол нь дулааны төвлөрсөн шугам сүлжээнд дийлэнх хэсэгтэй холбогдоогүй байгаа. Гэр хороолол дахь албан байгууллагууд нүүрсэн галлагаат бойлороор, айл өрхүүд нь сайжруулсан шахмал түлшин галлагаат зуухыг ашиглаж дулаанаа хангадаг. Дамбадаржаа дэд төв нь УБ хотын дулааны шугам сүлжээнээс 9.3км-ийн зайд орших бөгөөд уг дулааны шугамыг УБ хотын хойд хэсэгт орших Дамбадаржаа дэд төв рүү салбарлан татах ажлыг төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй дулааны хэрэгцээг хангахын тулд дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэх зорилгоор шинээр дулааны станц барих, одоо байгаа станцын хүчин чадлыг өргөтгөх зэрэг ажилд нийт 280 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг сүүлийн 3 жилд хийгээд байна. Хэдийгээр УБ хотын дулааны эх үүсвэрийн хүчин чадал нилээд хэмжээгээр нэмэгдсэн хэдий ч энэ нь Дамбадаржаа дэд төвийг дулааны хэрэгцээг шийдэхэд хангалттай бус байна. Иймд төслийн хүрээнд Дамбадаржаа дэд төвийг дулаанаар хангах 58 мВтг хүчин чадалтай дэвшилтэт технологи бүхий 130/70 хэмд усыг халаах тус бүр 18 Гкал чадалтай НТБҮШ зуухтай дулааны станцыг Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны нутагт барихаар төлөвлөн ТЭЗҮ-г боловсруулах шатандаа явж байна. Дулааны станцын барилгажих талбай 22000м2, барилгын ашигтай талбай 18000м2 байна. Газар чөлөөлөлтөнд 37 нэгж талбар өртөнө. Тус дулааны станцын төсөлд тусгайлан БОННУ хийгдэх тул энэхүү тайланд дулааны станцын талаар оруулаагүй болно. Шинээр баригдах дулааны станцаас Дамбадаржаа дэд төв рүү 150-350 мм-ийн голчтой, 2594 метр урт дулааны шугам хоолойг татах бөгөөд уг хоолойгоор 24.51 Гкал дулаанаар дэд төвийг хангана. Мөн 7 байрлалд дулааны дэд станцыг барьж байгуулна.</p>						
<p>DARI-1 Авто зам шугам сүлжээ барилгын ажил</p>	<p>Төслийн төлөвлөлт</p>	<p>Төслийн хүрээнд хийхээр төлөвлөгдсөн дэд бүтцийг хөгжүүлэх ажлын тоо хэмжээг доорх хүснэгтэд чиглэл тус бүрээр нь хураангуйлан үзүүлэв</p> <table border="1" data-bbox="635 1906 1426 2002"> <thead> <tr> <th>Гэрээний дугаар</th> <th>Дэд бүтцийн ажлууд</th> <th>Ажлын тоо хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>DARI-1</td> <td>Авто зам</td> <td>1063м урттай, 7м өргөн</td> </tr> </tbody> </table>	Гэрээний дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ	DARI-1	Авто зам	1063м урттай, 7м өргөн
Гэрээний дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ						
DARI-1	Авто зам	1063м урттай, 7м өргөн						

			Дулаан хангамж	Дулааны шугам- 1141м, диаметр (Ф150-350мм) Дулааны дэд станц 3нь байрлалд
			Цэвэр ус хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1044 м
			Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: Ф200~300мм, урт= 1817 м
			Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 863 м, өргөн 1-1.5 м
DARI-2 <i>Авто зам шугам сүлжээ барилгын ажил</i>		Төслийн хүрээнд хийхээр төлөвлөгдсөн дэд бүтцийг хөгжүүлэх ажлын тоо хэмжээг доорх хүснэгтэд чиглэл тус бүрээр нь хураангуйлан үзүүлэв		
		Гэрээний дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ
		DARI-2	Авто зам	1526м урттай, 7м өргөн
			Дулаан хангамж	Дулааны шугам Урт= 1453 м, диаметр (Ф150~350мм) Дулааны дэд станц: 4 байрлалд
			Цэвэр ус хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1360 м
			Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: D200~300мм, урт= 1214 м
Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 522 м, өргөн 1-1.5 м			
Бичиг баримтын бүрдэл	Байгууллагын гэрчилгээний хуулбар: Тусгай зөвшөөрөлийн хуулбар : ХАБЭА-ний дотоод журам: Хог хаягдын гэрээ: Цахилгаан хангамжийн эх үүсвэрийн гэрээ: Ус ашиглах гэрээ: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Лабораторийн шинжилгээний дүн:			
GWD- <i>хөрсний усны түвшин доошлуулах дренажийн ажил</i>	Төслийн төлөвлөлт	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын нэг хэсэг нь GWD буюу Дамба дэд төвийн дэд бүтцийн шугамын дагуух хөрсний усны түвшин доошлуулах дренажийн ажил юм.		
	Төслийн хүчин чадал, техник технологи	Дамба дэд төвийн дэд бүтцийн шугамын дагуух хөрсний усны түвшин доошлуулах дренажийн ажлын зураг төслийн урт – Дренажийн шугам: урт 522 м, өргөн 1-1.5 м Дамжуулах хоолойн байрлах гүн - Хоолойн материал- төмөр бетон хоолой Шугамын байгууламжийн тулгуур суух гүн – Төлөвлөж буй тулгуурын төрөл- нягтруулсан хөрс		
	Бичиг баримтын бүрдэл	Байгууллагын гэрчилгээний хуулбар: Тусгай зөвшөөрөлийн хуулбар : ХАБЭА-ний дотоод журам: Хог хаягдын гэрээ: Цахилгаан хангамжийн эх үүсвэрийн гэрээ: Ус ашиглах гэрээ: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Лабораторийн шинжилгээний дүн:		

1.2.2 ASKG-DA гэрээний багц: 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн төлөвлөлт

Хүн амын эрчимтэй өсөлтийн нөлөөгөөр хүүхдийн цэцэрлэгийн хүрэлцээ хангамж нь УБ хотын гол тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа билээ. Дамбадаржаа дэд төвд хийсэн олон нийтийн уулзалт, хэлэлцүүлгүүдийн үр дүнгээр ч энэ нь батлагдсан юм. Хүүхдийн цэцэрлэг баригдсанаар 150 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол үйлчилгээнд хамрагдах боломжтой.


Төлөвлөж буй хүүхдийн цэцэрлэгийн барилга нь Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдана. Тус цэцэрлэг нь гадна авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, хагас зоорийн давхартай ба 150 хүүхдийн хүчин чадалтай 2 давхар төмөрбетон каркастай 792 м² цэцэрлэгийн барилга, 975 м² тоглоомын талбай/, 1430 м² талбайтай, 19900 м² гадна задгай зам талбайтай байна.

Зураг 1-4. Төлөвлөж буй цэцэрлэгийн ерөнхий төлөвлөлт



1.2.3 ДАЕС гэрээний багц: Цахилгаан, холбоо, интернэтийн шугам сүлжээ татах ажил

Дамбадаржаа дэд төвд Мэдээлэл холбооны техникийн өрөөний барилгыг эхний ээлжинд барьж байгуулна. "Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд бүсүүдийг холбосон их багтаамжийн цагирган сүлжээ үүсгэх зорилгоор 3 км өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ байгуулна.



ХОЛБОО МЭДЭЭЛЭЛ – ТӨЛӨВЛӨЛТ

	Нийт хүчин чадал	Шугамын урт	Бусад
Холбооны худаг сувагчлал	4-6 эгнээ	6,3 км	Ф 110 мм
Шилэн кабель		3 км	



1.2.4 СЕР гэрээний дугаартай: 58-р сургууль болон 83-р ус түгээх байр орчмын тохижилтын ажил:

58-р ерөнхий боловсролын сургуулийн тохижилт

Төлөвлөлтийн нийт талбайн 525.12м²-ийг Автобусны зогсоол, 152.58м²-ийг явган хүний зам талбай, 123.92м²-ийг шат, 258.8м²-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн налуу зам, 132.77-ийг ногоон байгууламжийг тус тус төлөвлөсөн болно.


Цэцэрлэгжүүлэлт:


Голт бор нь 50х50, 60х60 хэмжээтэй нүхэнл хоорондоо 2-3 м зайтай 17 ширхэгийг тарина. 258.8 м² талбайд зүлэгжүүлэлт хийгдэнэ. Ногоон байгууламжийн моддын сонголтыг архитектур дизайны үүднээс сонгосон болно.



83-р ус түгээх байр

Төлөвлөлтийн нийт 328.32м² талбайн 45% буюу 148.437м²-ийг тоглоомын талбай, 1.7% буюу 5.817м²-ийг явган зам, 17.2м²-ийг ногоон байгууламж эзэлж байна. Ерөнхий төлөвлөгөөний тохижилтонд дараах элементүүдийг төлөвлөсөн болно. Зүлэгжүүлэх талбайн 1м² талбайд 60-100г үр ноогдохоор тооцно. Моджуулалт: Хайлаас нь жил бүр цэцэглэж үрэлдэг мод юм. Байгаль цаг уурын харилцан адилгүй бүс нутгуудад зохицон ургах биологийн онцлогтой модлог ургамал юм. 5-10 метр өндөр ургадаг. Хайлаас нь ганл тэсвэртэй, сайтар усалж арчлахад үндэснээсээ амархан сэргэн ургадаг. Хайлаас нийт 21 ширхэгийг тарина. Модны сулгацыг хавар 4-р сарын 15-аас 5-р сарын 25 хүртэл тарина.





2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь 2024 онд явагдах барилгын ажлын үед байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав.

Дамбадаржаа дэд төв нь нийт 70.7 га талбайг хамрах ба засаг захиргааны хил хязгаарын хувьд Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хороодыг хамарна.


3 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

3.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Төлөвлөж буй Дамбадаржаа дэд төв нь Сүхбаатар дүүрэгт, ХТ-ийн хойд хэсгээс бкм зайд, Сэлбэ дэд төвийн төвийн талд байрладаг. Энэхүү дэд төв нь СБД-ийн 16,17,18-р хорооны нутагт нийт 70.7 га газрыг хамран Сэлбэ голын баруун талд оршдог. Дэд төвийн ихэнх хэсэг нь тэгш тал боловч урд болон хойд талаараа толгодтой. Дэд төвийн хөгжүүлэх гол онцлог нь Дамбадаржаалан хийд юм. Энэхүү хийд нь хотын гарал үүслийн цэгүүдийн нэг ба өргөн хэмжээний мод үржүүлгийн газар зүүн талд нь байрладаг. Дэд төв нь зуны цагт иргэд зуслан руугаа явахад дамжин өнгөрөх гол газрын нэг билээ.

Төслийн талбайн “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн “Дамбадаржаа бичил дэд төв” төслийн талбай нь хотын баруун хэсэгт орших бөгөөд Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөсч тохойрсон татам болон дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ.

Зураг 3-1. Дамбадаржаа дэд төвийн байршил, Засаг захиргааны хил хязгаар



3.2 Уур амьсгал

Төслийн талбай орших Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -38.3°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 36.9°C хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь (75.2°C) эрс тэс ялгаатай.

Жилийн дундаж температур нь 0.4°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.3°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 19.5°C байдаг байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 257.1 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 173.1 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 89 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна. Салхины зонхилох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруунаас нийт салхины чиглэлийн 22.1% баруун хойноос, хойноос 20%, баруунаас 13.5% давтагдалтай байдаг. Салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 2.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг байна.

3.3 Агаарын чанар

Цаг уурын орчны шинжилгээний газрын агаарын чанарыг хянах 100- айлын станцын мэдээг ашиглан тодорхойлов. Агаарын чанарыг хянах 100 айлын харуул нь Сүхбаатар дүүргийн 10-р хорооны нутагт байрлана.

2016-2018 онд төслийн талбай орчмын бүс нутгийн агаарын чанарын төлвийг тодорхойлох хяналтын цэгт хийсэн агаар дахь бохирдуулах бодисын жилийн дундаж агууламжийг Агаарын чанарын MNS 4585:2007 стандарт /АЧС гэх/ дахь хүлцэх хэм хэмжээ /XXX/-тэй харьцуулахад хүхэрлэг хийн агууламж 0.014 мг/м^3 -д хүрч 0.7 дахин, том ширхэглэгт тоосонцорын агууламж 0.117

мг/м³-д хүрч 2.9 дахин, нарийн ширхэглэгт тоосонцорын агууламж 0.064 мг/м³-д хүрч 2.56 дахин, азотын давхар ислийн агууламж 0.017 мг/м³-д хүрч 0.4 дахин тус тус их байсан байна. 100 айлын харуулын 2016-2018 оны хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 0.014 мг/м³ буюу Агаарын чанарын стандарт (MNS 4585:2016, жилийн дундаж агууламж – 0.020 мг/м³)-аас давсан бохирдолгүй байсан бол жилийн дундаж агууламж 2016 оноос 0.016 мг/м³-ээс 2017 онд 0.010 мг/м³ болж буурч байгааг илтгэж байна.


3.4 Геологийн тогтоц ба геоморфологи

3.4.1 Геологийн тогтоц

2004-2005 оны геозкологийн региональ судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын дэвсгэр талбайд болон зэргэлдээх зарим дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн тогтоцын хувьд доод-дунд девон, доод-дунд карбоны настай тунамал-бялхмал-хувирмал чулуулгийн зузаалаг, дээд триас-доод юрийн настай гүний шургамал чулуулаг, доод цэрд, неогены плиоцены үеийн шаварлаг, түүнчилэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас зонхилон тархажээ. Иймд тухайн бүс нутгийн геологийн тогтоцын дээр дурьдсан өвөрмөц онцлогийг үндэслэн, 2004-2005 онд явуулсан геозкологийн региональ судалгааны талбайд тархсан нийт насны хурдас, чулуулгийг дараахи давхарга зүйн ангилалд хамааруулж байна. Үүнд:

- Доод-дунд девоны настай тунамал-бялхмал-хувирмал чулуулгийн зузаалаг (D₁₋₂)
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг (C₁₋₂)
- Дээд триас-доод юрын настай гүний шургамал чулуулгийн массив(Т₃-J₁)
- Доод цэрдийн настай тунамал хурдасны зузаалаг(K₁)
- Неогены плиоцены үеийн шаварлаг хурдасны зузаалаг(N₂)
- Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас / Q /

Зураг 3-2. Төслийн талбай орчмын геологи



3.4.2 Геоморфологийн нөхцөл


Төслийн бүс талбай орчмын бүс нутгийн геоморфологийн нөхцлийн хувьд газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн хэв шинжийн элэгдэл, идэгдэл-элэгдэл-хуримтлал болон хуримтлалын төрлийг ялгаж болно. Өндөр уулын бүсийн усан хагалбарын мужид зөвхөн газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн элэгдлийн хэв шинж зонхилж байхад намхан хэлхээ уул, бэсрэг толгодын хажуу ташлаг, энгэр, бэл, хормой болон гуу жалга, дэнжийн мөргөцгийн хэсэгт гадаргуугийн идэгдэл-элэгдэл-хуримтлалын төрөл давамгайлдаг.

3.5 Гадаргын ус

Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн Дамбадаржаа-гийн хэсгийн гадаргын усны төлөв байдлын талаар тусгалаа.

Улаанбаатар хотын дэвсгэр талбай болон зэргэлдээх зарим дүүргийн бүс нутаг нь газар зүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсын муж, түүнчлэн Туул голын ай сав, түүний хажуу жигүүрийн жижиг цутгал голуудын хөндийн хэмжээнд багтаж байрладаг.

Зураг 3-3. Судалгааны талбай орчмын гадаргын усан сүлжээ



Энэ бүс нутагт байгалийн тогтоц, уур амьсгалын нөхцлөөсөө хамааран гадаргын усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн. Судалгааны талбайд ойролцоо орших гадаргын усан сүлжээ нь Сэлбэ, Туул голууд бөгөөд судалгааны талбайд хамгийн ойрхон нь Сэлбийн гол юм.

3.5.1 Сэлбэ гол

Сэлбэ гол нь Бага Хэнтий нурууны баруун урд хажуугийн салбар бэсрэг уулс болох Их Баян уулын (2033 м) ба Цохиот уулын (1706 м) завсараас эх авах ба Их баян ба Багабаян голуудын уулзвараас Сэлбэ нэртэй болж, Туул голд Улаанбаатар хотын Дулааны 4 дүгээр цахилгаан станц орчмоор цутгана. Голын дагуу Хандгайт, Шарга морьт, Яргайт, Бэлх зэрэг жижиг гол горхи, булгууд болон хур бороо элбэгтэй үед хоёр хажуугийн уулсаас хуурай сайрууд усжиж Сэлбэ голыг тэжээнэ.


Сэлбэ голын нийт урт ойролцоогоор 30 орчим км бөгөөд ус хурах талбай нь ойролцоогоор 300 км² гаруй болно. Голын урсацын 15-40%-ийг ул хөрсний ус эзлэх ба ус хурах талбайн усан хагалбарт ойртох тутам багасаж, голын адгаар нэмэгдэх зүй тогтолтой.

3.6 Газрын доорх ус

Энэхүү бүлэгт судалгааны талбай, түүний ойр орчмын газрын доорх усны байгалийн суурь нөхцөлийг тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн хэмжээнд тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцлийг илэрхийлж буй газрын доорх усны тархалт, бүрэлдэн тогтолтын байгалийн ерөнхий зүй тогтол болон геологийн тогтоцын суурь нөхцлийн өвөрмөц онцлогийг үндэслэн, гидрогеологийн давхрага зүйчлэлийн хувьд дараах уст үе давхарга, цогцолбор, газрын доорх усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна Үүнд:

- Голоцены үеийн аллювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (alQ₂)
- Дунд-дээд плейстоцений үеийн делюви-пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (dpQ₁₋₂)
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг дахь уст цогцолбор (C₁₋₂) зэрэг болно.

Зураг 3-4. Төслийн талбай орчмын гидрогеологи



3.7 Хөрсөн бүрхэвч

Судалгаа явуулсан нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн баруун хэсгийн 39-р тойргийн (Үндэсний атлас, 2009) нутгийг хамран байрлах бөгөөд хотжилт, гэр хорооллын нөлөөгөөр *Хот суурингийн эвдэрсэн хөрс* болон өөрчлөгдсөн байна (“Монгол орны хөрсний джитал зураглал, хөрсний шинэчилсэн ангилал” сэдэвт ажлын тайлан, 2014). Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 16, 17, 18-р хорооны нутаг, Дамбадаржаа орчмын газар нь талархаг гадаргыг хамарч далайн түвшнээс дээш 1340-1380 орчим метрийн өндөрт байрлана.



Хот суурингийн эвдрэлд их өртсөн хөрс. Дамбадаржаа орчмын Билгэхийн голын хөндий хэсгээр аллювийн ширэгт бараан хөрс болон аллювийн сайргархаг хөрсүүд бүрдэл байдлаар тархдаг байсан ба сүүлийн жилүүдийн хүн амын төвлөрөл, гэр хороололын айл өрхүүд нэмэгдсэний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдрэл, доройтолд орж байгалийн унаган төрхөө бүрмөсөн алдсан тул хөрсний шинэчилсэн ангиллаар *Хот суурингийн эвдэрсэн хөрсний* ангилалд багтах болсон.

- “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл хэрэгжүүлэхээр Дамбадаржаагийн гэр хороололд – 70.7 га талбайг сонгосон байх ба энэ орчмын газруудын дийлэнх хэсгийг гэр хорооллын эвдэрч, доройтсон газар эзлэх ба барилга байгууламж бүхий газар бага хэсгийг эзлэнэ.
- Дамбадаржаагийн гэр хорооллын энэ орчимд анх байгалийн нөхцөлдөө Аллювийн ширэгт бараан болон аллювийн сайргархаг хөрсүүд бүрдэл байдлаар тархдаг байсан хэдий ч хотжилт, хүн амын өсөлт, төвлөрөлийн нөлөөгөөр хот суурингийн эвдэрсэн хөрстэй болсон байна.

3.8 Ургамлан нөмрөг

Сүүлийн жилүүдийн хотын хүн амын механик өсөлт, гэр хорооллын өсөн нэмэгдэж байдал нь ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлж суурьшлын бүс бүхий газрууд, тэр дундаа хашаа хоорондох гудамж талбай ургамалгүй, халцгай нүцгэн болох нөхцөл улам бүр нэмэгдэж байна. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл хэрэгжих Сүхбаатар дүүргийн 16,17,18-р хорооны Дамбадаржаа орчмын гэр хорооллын нутаг дэвсгэрт явуулсан судалгаагаар ургамалжилт дараахи байдалтай байна. Үүнд:

Гэр хороолол хэт их төвлөрсөн, гудамж хоорондох зай талбай бага байхын зэрэгцээ хашаа хоорондох гудамжиндаа авто замын нөлөөгөөр хөрсний эвдрэл ихээр үүссэн, ихэнхдээ ургамалгүй халцгай нүцгэн байна. Гэр хорооллын зарим гудамжны хашааны ёроол хэсгийн нарийхан зурвас газарт алаг цоог ургамалтай байна. Айлуудын хашааны ёроол хэсгийн багахан зурвас хэсэгт армаг тармаг ургасан хиаг, лууль, халгай бүхий ургамалтай байх ба тэдгээрийг дараах зургуудаар харууллаа.

Зураг 3-5. Гэр хорооллын хашаа хоорондох гудамжны ургамалгүй, ерөнхий төрх байдал




3.9 Амьтны аймаг

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 16,17,18-р хороонд хэрэгжих “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” –ийн “Дамбадаржаа бичил дэд төв” нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Хэнтийн тойрогт багтах бөгөөд Нийслэлийн хотын суурьшлын бүс нутагт оршиж байна. Төсөл хэрэгжих талбай, түүний орчмын бүс нутагт хүн амын хэт төвлөрөл, хотжил, хүн малын нөлөө, бэлчээрийн талхлагдал зэргийн нөлөөллөөс амьтны аймгийн амьдрах нөхцөл алдагдаж зөвхөн хот суурин газарт амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.

3.10 Тусгай хамгаалалттай газар нутаг

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 16,17,18-р хороонд хэрэгжих “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” –ийн “Дамбадаржаа бичил дэд төв” нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцахгүй юм. Тус төслийн талбайгаас улсын тусгай хамгаалалттай Богдхан уулын ДЦГ урд зүгт 10.7 км, Чингэлтэй уулын БНГ-ын 2-р хэсэг баруун хойд зүгт 11.2 км, дүүргийн тусгай хамгаалалттай Бурхантын хэмээх газар баруун хойд зүгт 18.4 км, Сонгинохайрхан уулын тусгай хамгаалалттай газар баруун урд зүгт 21.9 км зайтай оршдог.

Зураг 3-6. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд



3.11 Түүх, соёлын өв

Төслийн талбайд Эс И Си ХХК-ийн судалгааны багийн 2019 оны 9 сард хийсэн байгаль орчны төлөв байдлын хээрийн судалгаагаар түүх, соёлын өв бүхий ямар нэгэн дурсгал илрээгүй байна. Түүх соёлын өв

Дамбадаржаа хийдийн цогцолбор

Дамбадаржаа буюу Шашныг бадруулагч сүмийг Манжийн хааны зарлигаар хоёрдугаар Богд Жавзундамба хутагтын дурсгалд зориулан 1761-1765 онд баруун, зүүн Сэлбэ голын уулзварт байгуулжээ. Энэ үйл явдалтай холбогдуулж 1765 онд манжийн хааны зарлигийг тэмдэглэн, мөн Шашныг бадруулагч сүмийн тухай холбогдох зүйлийг гэрэлт хөшөөнд монгол, төвөд, манж, хятад



хэлээр сийлж, сүмийн гол хаалганы баруун, зүүн талд байрлуулсан бөгөөд байгалийн элэгдлээс хамгаалах зорилгоор дээр нь асар босгожээ

Анх БНМАУ-ын СнЗ-ын 1961 оны 524 дүгээр тогтоолоор улсын хамгаалалтад авсан бол хамгийн сүүлд Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор мөн улсын хамгаалалтад бүртгэн авсан байна. Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороо, Дамбадаржаагийн гудамжны баруун талд байдаг. Улаанбаатар хотын төв цэгээс зүүн хойш 9 км зайтай.

4 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно. Нөлөөлөлд өртөх орчны өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох байгаль орчны суурь судалгааг төслийн БОТБҮ-ний шатанд хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр судалгааны үр дүнгүүдийг нөлөөллийн үнэлгээ тус бүрийн эхэнд товч дурдсан болно.

4.1.2 3.2 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга зүй

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хэмжээ тархалт (M) 1, 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа)
Хамрах хүрээ (S) 1, 2 ба 3	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан)
Давтамж/магадлал (F) 1, 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно (**Error! Reference source not found.**). Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн 3 охицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

Хүснэгт 1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны хүчин зүйл	Эрчим		Тайлбар
	М x S x F	Нөлөөллийн үнэлгээ, эрчим	
Агаарын чанар	2x2x3	Сөрөг дунд	Тоосжилт үүсэх (эвдэрсэн хөрс салхиар элэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, цемент гэх мэт дэгдэмхий нунтаг материал ашиглах үед) Дуу шуугианы түвшин нэмэгдэх (Барилгын ажилд ашиглагдах машин тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн). Орчны агаар дах зарим хий төлөвт бохирдуулагчдын агууламж нэмэгдэх
	2x2x3	Сөрөг дунд	Тухайн орчинд авто машины тоо хэмжээ нэмэгдэнэ. Ингэснээр орчны агаар дах зарим хий төлөвт бохирдуулагчид болон хүнд металлын агууламж нэмэгдэнэ.
	2x2x3	Сөрөг дунд	Барилгын ажил явагдах явцад дуу чимээ үүсэх бөгөөд сөрөг нөлөөлөл болох магадлал их байна. Зам баригдан ашиглалтад орсноор дуу чимээний нөлөөлөл багасаж, зам дагуу байрших айлуудад эерэг нөлөөлөл үзүүлнэ.
Газрын гадарга	2x2x3	Сөрөг дунд	Барилгын ажлын техник хэрэгслийн хөдөлгөөний тоос шороонд дарагдах, нягтаршиж элэгдэл, эвдрэлд орно Барилгын ажлаас үүссэн тоос, шороо салхиар зөөгдөн ойр орчимд тархаж газрын гадаргад нөлөөлж болзошгүй.
Хөрсөн бүрхэвч	1x3x3	Сөрөг дунд	Барилгын явцад нөлөөлөлд өртөх хөрсний талбай нь төслийн талбайгаар хязгаарлагдах бөгөөд бүтээн байгуулалтын явцад ухсан талбай, овоолго шороо нь хөрсний эвдрэл, доройтол үүсгэх бөгөөд цаашид урсгал засвараас бусдаар хөрсний шинж чанарт нөлөөлөх нөлөө багатай. Барилгын ажлын үед эвдрэлд өртсөн талбайг богино хугацаанд нөхөн сэргээх боломжтой. Газар ашиглалтын эрчим нэмэгдсэнээр хөрсний эвдрэл эрчимжинэ.
Ургамлан нөмрөг	2x2x3	Сөрөг дунд	Барилга байгууламж түүнийг барихтай холбоотой гарах хог хаягдал, барилгын үйл ажиллагаанаас буй болох тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр бууж хуримтлагдах, ургамлын ургах чадварыг алдагдуулах Мөн барилгад ашиглагдах хүнд даацын ачааны машины хөдөлгөөний улмаас ургамлан нөмрөг зулгарах, тоосжилт үүсэх, ургамал бүрхэвч талхлагдах сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой. Дэд бүтцийн ажлын явцад нөлөөлөлд өртөх хөрсний талбай нь төслийн талбайгаар хязгаарлагдана. Барилгын талбайн ойр орчмын ургамлан нөмрөг хүнд элементээр бохирдох
Усан орчин	2x2x3	Сөрөг дунд	Төслийн үйл ажиллагаанаас гарсан ахуйн бохир ус, машины зогсоолын угагдсан бохир ус зэрэг нь хөрсөнд нэвчиж гүний усыг бохирдуулах. Барилгын ажлын үед гадаргын болон газар доорх усны бохирдолтод нөлөөлөх Аллювийн хурдасны нягт өөрчлөгдөн сийрэгжсэний улмаас идэвхтэй дренаж явагдах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт нөлөөлөх хүчин зүйл нь барилгын ажлын үед хийгдэх газар шорооны ажлууд, шороон материал зөөж тээвэрлэх, овоолго хийх болон ажлын явцад элэгдэж талхлагдсан газраас босох тоос, тэнд ашиглагдаж байгаа машин механизм, тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх түлшний дутуу шаталтаас үүсэж агаарт цацагдах хорт хий бүхий утаа болно. Төслийн талбайд үүссэн агаарын тоос, бохирдол нь салхины зонхилох чиглэлийн дагуу баруун хойноос зүүн урагш чиглэлд тархах боломжтой. Шугам сүлжээний ажлын явцад дараах сөрөг нөлөөлөл үүсэхээр байна. Үүнд:

- Барилгын ажлын суурь ухах, талбайн цэвэрлэгээ тэгшилгээ хийх, барилгын материал ачиж буулгах зэрэг ажлаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулна. Төслийн байршлийн хүрэх зам хатуу хучилттай тул тээвэрлэлтийн үед замын нөхцөлөөс шалтгаалан тоосжилт үүсэхгүй.
- Авто машин бусад тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал ялгарна.
- Хаягдал шороон материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудыг зохих хамгаалалттайгаар хийж гүйцэтгээгүй нөхцөлд орчны агаарт тоосжилт үүсгэж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмж болон барилгын материал, хэрэгсэл тээвэрлэх иргэдийн тээврийн хэрэгслийн яндангаас хаягдал хий үүсэх, агаар орчныг бохирдуулах
- Хүчтэй салхины улмаас барилгын суурь ухах явцад болон овоолгоос тоосжилт дэгдэх.
- Дуу шуугиан, доргио чичиргээ үүсэх

Газрын гадарга ба газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Өнөөгийн байдлаар төслийн талбайд газрын гадаргын болон хэвлийн эвдрэлд өртөөгүй байгаа бөгөөд төслийн хүрээнд барилга байгууламжийг барихдаа ургамлын үет хөрсийг зайлуулах, талбайг тэгшлэх, төслийн барилга, ариун цэврийн газрын суурийн нүх ухах, газар доорх инженерийн барилгын ажил гүйцэтгэх газар ухах, шороог зөөх, асгах, түрэх, овоолох, тараах, нягтруулах, нүхийг буцаан булалт хийх зэрэг газар шорооны ажил хийгдэх бөгөөд эндээс газрын гадарга эвдэгдэнэ. Үүнд.

- Гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орно
- Барилгын суурь ухах газар шорооны ажлаас хаягдал шороон материал үүсэх
- Барилгын ажлын ажлын үед ажилчдын түр амрах байр, гал тогооноос гарсан ахуйн гаралтай хог хаягдлаар газрын гадарга бохирдож болзошгүй
- Барилгын ажлын ажлын үед барилгын болон ахуйн хог хаягдлаар газрын гадарга бохирдож болзошгүй

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх эвдрэл, өөрчлөлтийн ихэнх нь газрын гадаргад хамрагдах бөгөөд барилгын ажлын ажлын үед эвдрэл эрчимтэй явагдах төслийн үйл ажиллагаа дууссаны дараагаар гадна тохижилтын ажил хийгдэнэ.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн зүгээс хөрс элэгдэж эвдрэх, бохирдох нөлөөлөл барилгын ажлын үед үүснэ. Барьж байгуулах үед хөрс хуулах, түрэх, овоолго хийх, хучилт хийх, ухмал хийх гэх мэт ажлын явцад хөрс, гадаргын урсцад өөрчлөлт орж хөрс хөндөгдөх, дарагдах, ургамлан бүрхэвч устах нөлөөлөл бий болох бөгөөд үүнд газрын гадаргын хэвгий, хөрсний шинж чанар, ургамалжилт зэрэг хүчин зүйлд нөлөөлөлж болзошгүй. Барилгын суурь ухах, гадна зам талбайн тохижилт хийх ажилд талбайн өнгөн хөрс хуулагдана. Барилга барих барилгын үе шатанд дараах болзошгүй нөлөөлөл үүсэхээр байна. Үүнд:

- Барилгын болон ахуйн хог хаягдлыг замбараагүй зайлуулах болон ажилчдын кэмпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдлоос үүдэлтэй хөрсний бохирдол үүсч болзошгүй
- Техник хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэх
- Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч гоожин хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.
- Машин техникт шатахуун хийх үед анхаарал болгоомжгүй хандсанаас шатахуун алдагдаж хөрс бохирдуулах
- Хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанарт өөрчлөлт гарч болзошгүй

Хөрсөнд учруулж болзошгүй нөлөөллийг үнэлж үзэхэд сөрөг үр дагаврыг “дунд” гэж үзэж болно.

Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбайн ургамлан нөмрөгт дараах сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- Барилгын ажлын ажлын улмаас ойролцоох газрын ургамлан нөмрөг тоосонд дарагдах, машин техникийн нөлөөгөөр талхлагдах доройтож болзошгүй.
- Газар шорооны ажлын үед хөрсний овоолгууд бий болж ургамлан нөмрөг дарагдаж болзошгүй
- Ашиглалтын үе шатанд ахуйн гаралтай хог хаягдлаас үүдэлтэй бохирдуулагч хөрсөнд нэвчиж ургамлан нөмрөгийн ургах орчинг өөрчлөх,сэргэн ургах чадварт нөлөөлж болзошгүй
- Авто машинаас шатах тослох материал хөрсөн дээр асгарч шингэх замаар хөрсний шим тэжээлийн бодисын найрлага өөрчлөгдөн ургамлын ургах чадвар буурах, ургамал бохирдож болзошгүй.
- Хүний замбараагүй үйл ажиллагааны улмаас Сэлбэ голын сав газрын ургамлан нөмрөг талхагдан бохирдож болзошгүй

Нөлөөллийн үр дагаврыг үнэлэхэд 100 хувь “бага нөлөөлөлтэй” гэсэн зэрэглэлд хамаарч байгаа тул уг төслөөс ургамал нөмрөгт сөрөг нөлөөлөл бага гэж үзэж болно.

Гадаргын болон газар доорх усанд үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжих явцад усны хадгалалт, хамгаалалт хангалтгүй, эсвэл ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй буюу огт байхгүй зэргээс усанд бактери үржин гэдэс ходоодны өвчний гол эх үүсвэр болж болзошгүй. Гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсч болзошгүй үүнд:

- Инженерийн шугам сүлжээ татах суваг шуудууг ухах, авто зам барих, зам доогуурх ус нэвтрүүлэх хоолой тавих зэрэг ажлаас гэр хороолол доторх үерийн урсацын жалга, сувгуудын бүтэц, хэлбэр, чиглэл түр хугацаанд буюу бүрмөсөн өөрчлөгдөх
- Хаягдал шороон материал болон бусад хог хаягдлыг Сэлбэ голын сав газарт хаяж бохирдол үүсгэх
- Тос тосолгооны материал, замын ажилд ашиглагдах асфальт бетон зуурмаг зэрэг бодис санамсаргүй байдлаар хөрсөнд асгарч улмаар хур борооны усаар зөөгдөн гадаргын усан сүлжээний усны найрлага, чанарт дам байдлаар нөлөөлж болзошгүй
- Барилгын ажилд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл Сэлбэ голын усны хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрч, машин тэргээ угаах зэргээр бохирдол үүсгэх
- Ажлын явцад техникийн нөхцөлийн хувьд хэвийн бус хүнд даацын машин механизм, автомашинууд болон авто замыг ашиглах үед тос, тосолгооны материалууд асгарч болзошгүй бөгөөд энэ тохиолдолд хур тунадас болон үерийн усаар угаагдан голдрилууудын

хурдсыг бохирдуулах, улмаар ил задгай устай нийлж гадаргын усыг бохирдуулах зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй

- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах барилгын материал хур борооны усаар угаагдан хөрсөнд нэвчин бага гүний уст үеүдийг бохирдуулах
- Ажилчдын кэмпээс үүсэх ахуйн хатуу, шингэн хог хаягдал, барилгын хог хаягдал зэрэг нь хур борооны усаар Сэлбэ гол руу зөөгдөн урсаж бохирдол үүсгэх
- Барилгын ажлын явцад газар ухах үед хөрсний усны шүүрэл үүсч болзошгүй
- Барилгын ажлын явцад шатах, тослох материал, асфальт бетон зуураг зэрэг бодис асгарч хөрсөнд шингэн, улмаар бага гүний уст үеүдийг бохирдуулж болзошгүй
- Барилгын суурь ухах, цэвэр, бохир ус, холбоо, цахилгааны шугам тавих шуудуу ухах газар шорооны ажлын үед хөрсний усны шүүрэл үүсч болзошгүй
- Дренажийн ажлын үед өнгөн хөрсний болон ул хөрсний усны түвшин дээшилж, халиа тошин, хөрс овойлт, суулт зэрэг улирлын цэвдэгтэй холбоотой үзэгдлүүд үүсэх
- Үерийн улмаас Сэлбэ голын усны түвшин огцом дээшилж, инженерийн барилга байгууламжийг эвдэх эрсдэл
- Дренажийн шугам хоолойн холбоосуудаар ус алдах, хагарах, хэв гажих, суулт үүсэх зэргээр эвдрэл гэмтэл үүсэх

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжих үйл ажиллагааны явцад амьтны аймагт дараах сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Үүнд:

- Хөрс хуулалт, газар шорооны ажлын үед мэрэгч амьтдын нүх оромж устах
- Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд хөрс хуулалт болон барьж байгуулах үед техник хэрэгслийн хөл хөдөлгөөн, дуу чимээ ихэссэнээс амьтад улам дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөж болзошгүй.
- Хог хаягдал түр хадгалах цэгийн битүүмжлэл алдагдсанаар шувуу болон жижиг амьтад хог хаягдлаар хооллон хордох, өвчин тарж болзошгүй

ТХГН, түүх, соёлын дурсгалт зүйлст учруулж болзошгүй нөлөөлөл

Барилгын газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй.

Нийгэм хүн амд нөлөөлөх нөлөөлөл

Төслийн барилгын үйл ажиллагаанаас оршин суугчид болон ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд дараах сөрөг нөлөөлөл үүснэ. Үүнд:

- Төслийн талбайд ойр үйл ажиллагаа явуулдаг сургууль, албан байгууллага, гэр хороолол, орон сууцны айл өрх зэрэг газрууд барилгын ажлын үед тоосжилт дуу чимээний нөлөөлөлд өртөх,
- Газар шорооны ажлын үед гарсан аливаа нүх, суваг шуудууг дарж булахгүй дутуу орхисноос унаж осолдох,
- Төслийн талбайн ажилчдын тав тухтай байдал дутагдах, хөдөлмөрийн сахилга бат хариуцлага зөрчигдөх, харуул хамгаалалтын журам алдагдсанаас зохисгүй харьцаа үүсэх, гэмт хэрэг гарах, халдварт өвчин тархах аюул үүсэж болзошгүй

- Барилга угсралтын үйл ажиллагааны үед барилга дээрээс юм унаж хүний эрүүл мэнд, эд хөрөнгө гэмтээх
- Барилга угсралт, газар шорооны ажлуудаас гэр хороолол дунд зорчих зам, орц, гарц хаагдаж боогдох
- Барилга угсралтын үйл ажиллагааны үед нунтаг цемент, шохой агаарт дэгдэж үзэгдэх орчныг хязгаарлах
- Шугам хоолойн холболт, барилга угсралтын үйл ажиллагааны үед зүсэх, гагнах ажлуудын үед хэлтэрхий буюу гагнуурын оч үсэрч явган зорчигчийг гэмтээх
- Барилгын материал тээвэрлэх үйл ажиллагааны үед зам тээврийн осол аваарь гарах буюу ус зөөж буй хүүхдүүд, явган зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учруулах
- Газар шорооны болон шугам хоолой, цахилгааны холболт угсралтын ажлын үед шугам хоолой холбох зорилгоор ухсан нүх, шуудуунд хүн унаж гэмтэх
- Газар шорооны ажлын үед хаягдал шороон материалыг зайлуулалгүй удсан тохиолдолд орчны төрх байдал алдагдах
- Өндөр температуртай асфальт болон бетон зуурмаг алдагдаж хүний гар хөл түлэгдэж гэмтэх
- Замын ажилд ашиглагдах хүнд даацын машин механизмууд осол аваарь гаргах

Хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн хог хаягдал, барилгын ажлын явцад ахуйн болон барилгын хог хаягдал үүсэх бөгөөд хог хаягдал үүсэх, тэдгээрийг хадгалах, устгахтай холбоотойгоор сөрөг нөлөөлөл бий болно.

- Төслийн үйл ажиллагаанаас жишээ нь ухалтын ажлаас гарсан хөрс шороо, барилгын болон ердийн хатуу хог хаягдал үүсэх,
- Ахуйн бохир ус зэрэг шингэн хаягдал үүсэх,
- Аюултай хог хаягдал болох ажилласан тос, тос тослох материалын сав, сольсон сэлбэг хэрэгсэл зэргийг зохих журмаар устгаагүй тохиолдолд байгаль орчныг бохирдуулах сөрөг нөлөөтэй.

4.1.3 3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Төслийн үйл ажиллагаанд ашиглах түүхий эд (элс, хайрга, цемент гэх мэт)-ийг тээвэрлэхэд тэвшнээс тоос тоосонцор дэгдэхээс урьдчилан сэргийлж тэвшийг бүтээх
- Нийт тээвэрлэлтийн явцад эвдэрсэн хөрс бүхий газрын гадаргаас агаарт дэгдэх тоос тоосонцрыг бууруулахын тулд төслийн талбайд зорчих нийт тээврийн хэрэгслүүдэд хурдны хязгаар тогтоох зорилгоор төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, суларсан хөрс бүхий задгай талбайгаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд төслийн талбайг чийгшүүлж услах, усалгааг хуурайшилт ихтэй үед өдөр бүр хийх,
- Төслийн үйл ажиллагаанд ашиглах нийт тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулах, оношилгоонд тэнцсэн буюу шаардлага хангасан машин, техник ашиглах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс цаг агаарын аюултай болон онц аюултай үед барилгын ажлыг зогсоох (цаг агаарын урьдчилсан мэдээ болон хуанли бүртгэж ажиллах)
- Барилга байгууламжийн ажлын үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, тогтсон нэг замаар зорчуулах хуваарь гаргах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах

- Ашиглаж буй машин механизм, техник хэрэгслээс гарах химийн хорт бодис бүхий хий, утааг багасгахын тулд барилгын ажилд ашиглаагүй үед унтраах
- Дуу шуугианы түвшнийг бууруулахын тулд барилгын ажил гүйцэтгэхэд дуу чимээ бага гаргадаг машин тоног төхөөрөмжийг сонгох, машин механизм, тоног төхөөрөмжид тогтмол засвар үйлчилгээ хийх, тэдгээрт дуу намсагч хэрэглэх, дуу чимээ ялгаруулалт багатай технологийн ажилбарыг ашиглах
- Дуу чимээ ихтэй ажлыг өглөө 8-оос орой 20 цагаас хойш хүртэл илүү цагаар ажиллах бол ойр орчмын иргэдэд ажил хийгдэхээс өмнө мэдэгдэх
- Шуугианы түвшнийг зохицуулж хянаж байх, чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглахгүй байх

Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Усны тухай хууль”-ийн заалтуудыг дагаж мөрдөх
- Сэлбэ голын усны хамгаалалтын бүс рүү барилгын ажилчид нэвтрэх, машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаяхыг хатуу хориглох
- Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх
- Барилгын ажлын явцад ахуйн болон шатах тослох материалуудыг зориулалтын агуулах, талбайд хадгалж ойр орчиндоо хаягдах, асгарах, тархах зэргээр орчноо бохирдуулахаас урьдчилан сэргийлэх хэрэв шатах тослох материал асгарсан үед, тархахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах
- Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх
- Усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар шүүрлийн усыг зайлуулах дренажийн ажлын зураг төсөл хийлгэх
- Тоосжилт дарах зорилгоор усалгаа хийхдээ усны норм стандартыг баримталж ажиллах, зориулалтын тээврийн хэсэглээр тээвэрлэж, шүрших
- Барилгын усны хэрэгцээг дэд төвийн гадна байгаа, зөвшөөрөгдсөн эх үүсвэрүүдээс усны машинаар ажлын талбайд хүргэх, ажлын талбарт том саванд хадгалсан усаар хангах
- Ажилчдын унд ахуйд ашиглах ус нь ундны усны стандартад нийцэж байх

Хөрсөн бүрхэвч, газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах
- Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүс рүү барилгын ажилчид нэвтрэх, машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаях болон аливаа барилгын үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглох Барилгын ажлын талбайн өнгөн хөрсний үржил шимт хэсгийг хадгалж техникийн нөхөн сэргээлт хийхэд ашиглах
- Тохижилт үйлчилгээний газартай барилгын ажлын явцад гарсан хог хаягдлыг тээвэрлүүлж зайлуулах гэрээ байгуулах
- Тоосжилтоос үүдэн ургамлын амьдрах чадвар буурч, фотосинтезийн үйл ажиллагаа явагдахгүй болох магадлалтай тул тоосжилт үүсэх эх үүсвэрүүдийг услах, тоосжилт үүсгэх арга замуудыг багасгах

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болох тул нэгдсэн нэг цэгт төвлөрүүлж, зохих стандарт шаардлагын дагуу устгана.
- Барилгын ажлын талбайгаас өөр талбайн ургамлан бүрхэвчийг хөндөхгүй хадгалан үлдээх
- Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд барилгын ажил дууссаны дараа газрыг тэгшлэн нөхөн сэргээх, зүлэгжүүлэх шаардлагатай хэсгийг ялзмагт давхарга бүхий хурааж хадгалсан үржил шимт хөрсөөрөө хучиж өгнө. Хучилт хийсэн хэсэгт нөхөн сэргээлтийн олон наст болон модлог ургамлыг тариална. Нөхөн тариалах ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний оролцоотойгоор зохион байгуулах

Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Барилга угсралтын үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд хатуу сахиж ажиллах
- ХААБ-ын стандарт журмыг мөрдөх, хамгаалах хэрэгсэл өмсөх, барилга баригдаж буй талбайг тойруулан хамгаалалтын хашлага татаж, анхааруулах тэмдэглэгээ байршуулах
- Зориулалтын хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөх, гагнуур хийгдэж буй цэгийг хашиж хамгаалах
- Ухрах, эргэх маневрыг зөвхөн дохиочны заавраар хийх
- Дуу чимээ ихтэй ажлыг зөвхөн өдрийн цагаар гүйцэтгэх, тоос дарах усалгааг байнга хийх, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөж хэвшүүлэх
- Урьдчилсан төлөвлөгөө гаргах, машин механизмын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах, шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх
- Жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны сургалтад давтан хамруулах, аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрдүүлэх, техникийн бүрэн байдлыг тогтмол шалгах, гэр хороолол доторх замд хурдны хязгаар тогтоох
- Газар шорооны ажлын цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж анхааруулах тэмдэг байрлуулах
- Шууд болон шууд бус нөлөөллийн нэг нь барилгын ажлын явцад зам ачаалалтай, түгжрэл үүсч болзошгүй. Үүнийг бууруулахын тулд өртөгч иргэд оршин суугчидтай зам ашиглалтын талаар мэдээлэл солилцож зөвлөлдөх нь зүйтэй.
- Машин механизмын бүрэн бүтэн байдлыг шалгах, машин механизмын ард улаан гэрэл, самбар тавих, машин механизмыг ашиглах явцад дохиочныг талбайд ажиллуулан бусад ажилчин орохыг хориглох
- Үйл ажиллагааны үед СХД болон хорооны удирдлагатай нягт хамтран ажиллах
- Төслийн талбайд ХАБЭА-ны мэргэжилтэн тогтмол ажиллах, өдөр бүр ажил эхлэхийн өмнө ажилчидад ХАА-ны зааварчилгаа өгөх
- Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлийг барилгын ажлын талбайд тогтмол өмсөж хэрэглэх.
- Экскаватор болон хүнд техникийг ашиглах зааварчилгааг ХАБЭА-ны инженер ажилчдад өгөх,
- Барилгын ажлын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага биелүүлж ажиллах, ажилчдыг аюулгүй ажиллагааны шаардлага биелүүлэн ажиллаж байгааг талбайн инженер, ХАБЭА-ны инженер хяналт тавих
- Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, санамсаргүй асгаралт үүсгэхээс сэргийлэх
- Зам барилгын ажлын талбарт ажиллаж буй ажилчид хамгаалалтын хувцас хэрэглэлтэй байх

- Зам барилгын ажил явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж, анхааруулах тэмдэг байрлуулан явган зорчигчийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авах
- Замын индүүдэгч, бетон зуурмаг, асфальт тээвэрлэгч, дэвсэгч зэрэг том оврын машин тэрэгний ажлын үед хяналтын дохиурчныг зайлшгүй ажиллуулах шаардлагатай ба том оврын машин тэрэг ухрах, эргэх маневруудыг зөвхөн хяналтын дохиурчны дохиогоор хийж гүйцэтгэх

Дренажийн ажлын /DARI-1, DARI-2/ явцад учрах болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах зарчмуудыг авч үзэн, хэрэгжүүлэх шаардлагатай.

1. DARI-1, DARI-2 ажлыг эхлүүлэхээс өмнө гүйцэтгэгч нь (а) газар зохицуулалтын асуудал хэрэв байгаа бол үүнийг эцэслэн шийдвэрлэсэн эсэх (б) дотоодын дүрэм журамд заасан тохиолдолд дэд төслүүдийн зарим тусгай газруудад ашиглагдах байгаль орчны нөлөөллийн үнэлгээ/ эсвэл бууруулах арга хэмжээг төр засгаар баталгаажуулсан эсэх (с) ХМБОЖ-ын шаардлагын дагуу гүйцэтгэгчийн зүгээс бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон тусгайлсан төлөвлөгөө, ажилбарыг ТУН болон орон нутгийн удирдлага баталгаажуулсан эсэх (с) хамгаалалын шаардлага, хэлцэл зөвлөлдөөн, мэдээлэл түгээх ажлыг хийж гүйцэтгэсэн эсэхийг мэдсэн байна.
2. ТУН-ийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн болон талбайн инженертэй хамтран бууруулах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. ТУН, талбайн инженер хамтран гүйцэтгэлийн хяналтыг тодорхой давтамжтайгаар тогтмол явуулж, хяналтын үр дүн, ололт, дүгнэлт үнэлгээг хийж, улирал бүр тайлагнана.
3. Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэлээр хангалттай хангаж, ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт явуулна. Хэрэв шаардлагатай бөгөөд тохиромжтой бол орон нутгийн ажиллагсдыг ажлын байраар хангагдах боломж бүрдүүлж, тэдгээрийг хүйс харгалзахгүйгээр авч ажиллуулах хэрэгтэй.
4. Цаг үргэлж гэр хорооллын оршин суугчид болон орон нутгийн засаг захиргааны төлөөлөлтэй уулзаж ярилцах, зөвлөлдөх арга хэмжээг авах ба мэдээлэл байнга очдог эсэхийг шалгах. Олон нийттэй харилцах /уялдаатай ажиллах хөтөлбөрийн хүрээнд оршин суугчдаас болон олон нийтээс ирсэн гомдолд цаг тухайд нь хариу өгч байх
5. Гүйцэтгэгчид хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгааг давтамжтайгаар хянах ажлыг талбайн хяналтын инженер хийх ба хэрэв шаардлагад нийцэхгүй иргэдээс гомдол ирсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авна. Гарсан үр дүнг БОМТ-ын биелэлтийн нэг хэсэг болгон тусгана.
6. Дренажийн ажлын хамрах талбайн ойр орчимд аюултай байж болзошгүй тухай, тээврийн хэрэгсэн, явган зорчигчид явах түр зам байгуулсан эсэх зэрэг мэдээллийг гэр хорооллын оршин суугчид болон орон нутгийн засаг захиргаа бүрэн олж мэдсэн, ойлгосон эсэхийг олж мэдэх шаардлагатай.
7. Гэр хорооллын оршин суугчид нь барилгын ажил дуусах хугацааны талаар мэдээлэлтэй байх, хэрэв ажлын явц төлөвлөгөөнөөс хоцрохоор байвал энэ тухай мэдсэн байх шаардлагатай. Оршин суугчид ямар нэгэн асуудал байвал гаргаж тавих, гүйцэтгэгч тэдгээр асуудлуудыг авч үзэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, сөрөг нөлөөлөл үзүүлэхээс сэргилэх нь чухал юм.

5 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй Төслийн Удирдах Нэгж хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **79 сая 719 мянга 337 төгрөг** болох бөгөөд зардлын хураангуйг доорх хүснэгтэд ангилан үзүүлэв.

Хүснэгт 5-1. Дамбадаржаа дэд төвийн 2024 БОМТ-ний зардлын хураангуй

№	Менежментийн арга хэмжээ	Гэрээт ажлын багцууд						Нийт дүн, мян.төг
		DARI-1	DARI-2	DAEC	ASKG-DA	GWD	CEP	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7,288,000	7,288,000	4,934,900	2,241,000	250,000	800,000	22,801,900
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,635,094	2,197,727	106,770	333,945	-	15,673,901	19,947,437
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1,000,000	1,000,000	1,000,000	-	-	-	3,000,000
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,160,000	2,160,000	2,160,000	2,160,000	-	2,160,000	10,800,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	740,000	740,000	740,000	740,000	740,000	740,000	4,440,000
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	3,210,000	3,210,000	2,460,000	1,710,000	5,320,000	2,820,000	18,730,000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг		9,579,227	10,141,860	7,300,903	5,778,078	9,054,133	22,193,901	79,719,337 (Барилгын ажлын гэрээний үнийн дүнд багтсан)

6 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 DARI-1 гэрээний дугаар бүхий барилгын багц ажлын хүрээнд 2024 онд бүтээн байгуулах дэд бүтцийн байгууламжууд:

- + Авто зам: 1063 м;
- + Дулаан дамжуулах шугам хоолой: 1453 м;
- + Цэвэр ус дамжуулах шугам хоолой: 1044 м;
- + Ариутгах татуургын шугам хоолой: 1817 м;
- + Дренажийн шугам хоолой: 863 м.

Хүснэгт 6-1. DARI-1 багцын 2024 онд хэрэгжүүлж ажиллах Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажилд нийт 2.4 газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	<ul style="list-style-type: none"> ▪ Инженерийн шугам хоолой тавих ажилд өртөж эвдэрсэн 270 м² талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, нөхөн дүүргэлт, тэгшилгээний ажлууд хийж, анхны төрх байдалд нь оруулах буюу илүү сайжруулан хэлбэршүүлж, орчны тохижилт үүсгэх ▪ Станцын нийт талбайн 10% буюу 2400 м² талбайд ногоон байгууламж үүсгэн тохижуулж, мод зүлэг тарих 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт			Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан		Барилгын ажил дуусах үед	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм
Газар шорооны ажлаас 21000 м ³ хаягдал шороон материал үүсэх	<ul style="list-style-type: none"> ▪ 2089 м³ хэмжээтэй шороон материалыг шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглах ба үлдсэн 18,022 м³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Чингэлтэй дүүргийн хог тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. ▪ Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт			Барилгын ажлын төсөвт багтсан		Газар шорооны ажил явагдах хугацаанд, 7 хоног бүр	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	<ul style="list-style-type: none"> Хаягдал шороон материалыг их хэмжээний овоолго үүсгэж хуримтлуулалгүйгээр тухай бүрт нь Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулж байх Газар шорооны ажлаас үүсэх шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх 						Газар шорооны ажил явагдах хугацаанд	
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Усны хэмжээ м3	12961	3000 ¹	2,888,000	Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй машинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношлогоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд					Барилгын ажлын туршид, 7 хоног бүр	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2000 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
	<ul style="list-style-type: none"> Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах 	Бүх тээврийн хэрэгсэл		ОХШХ-т тусган оруулсан			Барилгын ажлын туршид, Сар бүр	

¹ 6000 төг/м³- Гэр хорооллын бүсэд зөөврийн ус түгээх тариф

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
Барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас орчны агаарт тоосжилт үүсгэх	<ul style="list-style-type: none"> Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс хаягдал шороон материал ачих, барилгын материал буулгах зэрэг ажлыг түр зогсоох 	Барилгын ажлын талбай				Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага	
Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
Газар шорооны ажил, зам барилгын ажил, шугам хоолойн угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	<ul style="list-style-type: none"> Зам барилга ба барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд Барилгын ажлын талбай				Барилгын ажлын төсөвт багтсан ОХШХ-т тусган оруулсан	Барилгын ажлын туршид Сар бүр	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл	
Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	<ul style="list-style-type: none"> Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх Энэхүү тайлангийн 8-р бүлэгт оруулсан Хог Хаягдлын Менежментийн Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах Барилгын түр кэмп тус бүрт хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх 	Барилгын ажлын талбай, барилгын түр кэмп				Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.	Барилгын ажлын туршид	MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл.	
Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
Барилгын ажилд ашиглагдах машин техникүүд Сэлбэ голын усны хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй	<ul style="list-style-type: none"> Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Усны тухай хууль-ийн заалтуудыг дагаж мөрдөх, 	Сэлбэ голын усны хамгаалалтын бүс дагуу	Анхааруул ах тэмдэг байрлуула	1		100,000	100,000	Барилгын ажлын туршид	Усны нөөцийн төлбөрийн хувь хэмжээг тогтоож, хөнгөлөх тухай Засгийн газрын тогтоол

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
нэвтэрч, машин тэргээ угаах зэргээр бохирдол үүсгэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Сэлбэ голын усны хамгаалалтын бүс рүү барилгын ажилчид нэвтрэх, машин тэргээ угаах, түлш цэнэглэх, хог хаяхыг хатуу хориглох 		х цэгийн тоо					MNS0900:2018 Ундны ус.
Ажилчдын түр кэмпээс үүсэх ахуйн болон барилгын хог хаягдал зэрэг нь хур борооны усаар Сэлбэ гол руу зөөгдөн урсаж бохирдол үүсгэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> БОННУ тайлангийн 8-р бүлэгт заасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах Барилгын түр кэмпэд хог хаягдлын нэгдсэн цэг тогтоож өгч, хамгаалалтын хашлага хийх Чингэлтэй дүүргийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулсны үндсэн дээр цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачиж зайлуулж байх 	Барилгын түр кэмп, хогийн цэ	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.				Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд алдагдан, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчиж, гадаргын усны чанарт дам байдлаар нөлөөлөх болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	синтетик шингээгч материал (TSSW50W), ширхэг	1	100,000	100,000	Барилгын ажлын туршид	Усны тухайн хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах 	Ундны усны эх үүсвэр	тонн	Үйл ажиллагааны зардал багтсан			Барилгын ажлын явцад улирал бүр	MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
Барилгын түр кэмпийн үйл ажиллагаанаас үүсэх шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчих, шатах, тослох материал хөрсөнд асгарч улмаар бага гүний уст	<ul style="list-style-type: none"> Ажилчдын кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах Барилгын ажлын явцад ахуйн болон шатах тослох материалуудыг зориулалтын агуулах, талбайд хадгалж ойр орчиндоо хаягдах, асгарах, тархах зэргээр орчноо бохирдуулахаас урьдчилан сэргийлэх хэрэв шатах тослох материал асгарсан үед, тархахаас сэргийлж 	Барилгын түр кэмп, бүх нэгж хэсгүүд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.				Барилгын ажлын явцад 7 хоног бүр	Эрүүл ахуйн тухай хууль MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үеүдийг бохирдуулж болзошгүй	<ul style="list-style-type: none"> модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах Ажилчдын кэмийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх 							зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний болон ул хөрсний усны түвшин дээшилж, хөрсний усны шүүрэл үүсэх буюу халиа тошин, хөрс овойлт, суулт зэрэг улирлын цэвдэгтэй холбоотой үзэгдлүүд үүсч болзошгүй	<ul style="list-style-type: none"> Усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар шүүрлийн усыг зайлуулах дренажийн ажлын зураг төсөл хийлгэх Дренажийн ажил хийх тохиолдолд уг ажлын үед хэрэгжүүлэх Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө боловсруулж, Нийслэлийн БОГ-аар батлуулах бөгөөд уг төлөвлөгөөнд дренажийн ажилтай холбоотойгоор үүсэх байгаль орчны сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, зардал, хугацаа, хамрах хүрээ зэргийг тодорхой зааж оруулсан байна (зөвхөн шаардлагатай тохиолдолд). 	Газар шорооны ажил явагдах цэгүүд			Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын төсөвт багтсан		Барилгын ажил эхлэхээс өмнө	Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам БНБД 33-01-03 MNS 2990:1980 Хүлцэл суултын нэгдсэн систем. Метрийн эрээс. Үндсэн хэмжээ
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүсч болзошгүй	Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах	Барилгын материал тээвэрлэх зам дагуу,			Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан		Газар шорооны ажил явагдах хугацаанд	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Газар шорооны ажлаар хуулагдах 2.4 га талбайн өнгөн хөрс стандартын дагуу овоолго үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Дулааны салбар шугам тавих ажилд өртөж эвдэрсэн 270 м2 талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн дүүргэлт, нөхөн сэргээлтийн ажил хийх Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах 	Газар шорооны ажил явагдах цэгүүд			Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.		Барилгын ажлын дууссаны дараа	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлэх 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд				Барилгын ажлын төсөвт багтсан.		Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30.01.04 MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт Нөхөн сэргээлтийн стандарт MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008
Хог хаягдал, кэмпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсч болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх 	Барилгын түр кэмпүүд дэхь хогийн цэг, 00-ийн цэг				Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Эрүүл ахуйн тухай хууль MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Хүний замбараагүй үйл ажиллагааны улмаас Сэлбэ голын сав газрын ургамлан нөмрөг талхлагдан бохирдож болзошгүй	Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүс рүү барилгын ажилчид нэвтрэх, машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаях болон аливаа барилгын үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглох	Барилгын бүх ажилчид				Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ба энэхүү төлөвлөгөөний 4-р хэсэгт төсөвлөсөн төсвийн дагуу	Барилгын ажлын туршид	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
Нийгэм, олон нийгэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Барилгын материал тээвэрлэх, газар шорооны ажлуудаас тоосжилт үүсэх	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх 	Барилгын ажлын талбай				Энэхүү төлөвлөгөөний агаарын чанарын хэсэгт төсөвлөсөн төсвийн дагуу	Хуурай өдрүүдэд,	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	<ul style="list-style-type: none"> Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх 						өдөрт 4-5 удаа	MNS4990:2010 Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
Барилгын материал тээвэрлэх, газар шорооны ажлуудаас дуу чимээ үүсч ойр орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулах	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Шаардлагатай тохиолдолд дуу чимээ тусгаарлах зөөврийн хана ашиглах Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх 	Газар шорооны ажил явагдах цэгүүд, бүх тээврийн хэрэгсэл	Барилгын ажлын төсөвт багтсан				Барилгын ажлын туршид	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ
Дулааны салбар шугамын угсралт, газар шорооны ажлуудын үед гэр хороолол дунд зорчих зам, орц, гарц хаагдаж боогдох	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажлын улмаас тухайн зорчих хэсгийг түр хаасан талаарх болон тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд зориулан тогтоож өгсөн түр маршрутыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах Түр маршрутыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах Барилгын ажил явагдаж буй цэгүүдийн ойр орчимд явган хүн ба тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчих зам, орц гарцыг бий болгож өгөх Барилгын материал хураах, хөрсний овоолго үүсгэх цэгийг сонгохдоо оршин суугчдын хөдөлгөөнд саад учруулах буюу орц гарцыг хаахгүй байхаар төлөвлөх 	Барилгын ажлын бүх цэгт	Барилгын ажлын төсөвт багтсан				Барилгын ажлын туршид	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага.
Барилга угсралтын үйл ажиллагааны үед өндрөөс юм унаж хүн гэмтээж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилга угсралтын үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд хатуу сахиж ажиллах Баригдаж буй барилгыг тойруулан хамгаалалтын хашлага татаж явган зорчигч ойртохоос сэргийлэх Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах 	Хамгаалалтын хашлаганы урт	160м	5000	800,000	800,000	Барилгын ажлын туршид	Замын хөдөлгөөний аюулгүй басдлын тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Зүсэх, бутлах, гагнах ажлуудын үед хэлтэрхий буюу гагнуурын оч үсэрч явган зорчигчийг гэмтээж болзошгүй	Зүсэх, гагнах ажлууд хийгдэх цэгүүдийг тойруулж хамгаалалтын хашлага татах, анхааруулах тэмдэг байршуулах	Шугам хоолойн угсралт явагдах цэгүүд	Хамгаалалтын хашлага, самбар байрлуулах тоо	1	300,000	300,000	Зүсэх, гагнах ажил явагдах үед	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Цемент, шохой, элс зэрэг нунтаг материал агаарт дэгдэж үзэгдэх орчныг хязгаарлаж болзошгүй	Барилгын хэрэглэгддэг цемент, элс, шохой зэрэг нунтаг материалыг битүү орчинд буюу тусгайлсан саванд хадгалах	Барилгын ажлын талбай, материалын агуулах	Нунтаг бодис хадгалах зориулалтын савны тоо ширхэг	1	500,000	500,000	Барилгын ажлын туршид	
Барилгын материал тээвэрлэх үйл ажиллагааны үед зам тээврийн осол аваарь гарах буюу ус зөөж буй хүүхдүүд, явган зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын давтан сургалтад хамруулах, гэр хорооллын суурьшлын бүс дунд үүсч болзошгүй эрсдэл, осол аваарийн талаар тайлбарлан таниулах Гэр хороолол дунд тээврийн машины хурдыг хязгаарлах дүрэм мөрдүүлэх Тээврийн жолооч нарт худаг, хүүхдийн сургууль, цэцэрлэг, явган хүний гарц, уулзвар зэрэг осол аваарь гарах эрсдэл бүхий цэгүүд дээр 5 секунд зогсоод хөдлөх дүрэм мөрдүүлэх 	Тээврийн маршрут дагуу	Сургалтын тоо	2 удаа	400,000	800,000	Барилгын ажил эхлэхээс өмнө Барилгын ажлын туршид	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм
Тээврийн машинуудын байнгын хөдөлгөөн нь зуны саруудад хойд зуслан чиглэлийн замын хөдөлгөөний ачааллыг ихэсгэх нөлөө үзүүлж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилгын суурь ухах, шугам хоолой тавих суваг шуудуу ухах, зам тавих трассын хөрсийг хусч цэвэрлэх зэрэг хаягдал шороон материал их хэмжээгээр үүсгэдэг газар шорооны ажлуудыг зуслангийн оргил ачааллын улирал (6-8-р сар) эхлэхээс өмнө (4-5-р сард) буюу дараа нь (9-10-р сард) гүйцэтгэх ажлын хуваарь, төлөвлөгөө гаргах Барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын хөдөлгөөний оргил ачааллын цаг болох 	Тээврийн маршрут дагуу	Барилгын ажлын төсөвт багтсан, нэмэлт зардал гарахгүй				Барилгын ажил явагдах хугацаанд, зуны саруудад	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	<p>өглөө 07:00- 10:00 цаг болон орой 17:00-20:00 цагуудаас зөрүүлсэн цагийн хуваарь гаргаж зохицуулах</p> <ul style="list-style-type: none"> Нэн яаралтай бус зарим төрлийн бараа материалын тээвэрлэлтийг ажлын бус өдрүүдээр (Бямба, Ням гарагт) хийж гүйцэтгэх 							
Шугам хоолой тавих зорилгоор ухсан нүх, шуудуунд хүн унаж гэмтэх	Шугам хоолой байрлуулах зорилгоор ухсан нүх шуудууг хамгаалалтын торон хашлагаар хашиж хүрээлэх, анхааруулах тэмдэг байрлуулах	Шугам хоолойн угсралт явагдах цэгүүд	Торон хашлаганы урт, м	200	5,000	1,000,000	Газар шорооны ажлын туршид	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Кэмгийн орчинд хог хаягдал, бохир усыг замбараагүй зайлуулснаас үүдэн орчны бохирдол, үнэр танар үүсгэх	<p>Барилгын түр кэмп бүрт дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Хатуу хог хаягдлын менежмент. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, ЧД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх Шингэн хог хаягдлын менежмент. Кэмпээс гарах бохир усыг битүү саванд түр хадгалж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх Ажилчдын 00. Эрүүл ахуйн шаардлага хангасан 00- той байх, 00-н нүхэнд био-бэлдмэл ашиглаж халдваргүйжүүлэлт хийх, ойр орчмыг нь хлораминт шингэнээр тогтмол ариутгаж цэвэрлэх 	Барилгын түр кэмп, Барилгын ажлын бүх цэгт	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан				Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Эрүүл ахуйн тухай хууль MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Кэмгийн орчинд сахилга бат, хэв журмын зөрчил гаргаж оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилчдыг БОМТ, эрүүл ахуйн сургалтад хамруулж, зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулсан байх Кэмгийн орчинд мөрдөх дотоод журамд сахилга батын асуудлыг нарийвчлан тусгаж өгөх ба үүнд согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэргийг хатуу хориглох 	Барилгын бүх ажилчид	Сургалтын тоо	2 удаа	400,000	800,000	Жил бүрийн барилгын ажлын эхэнд	Зөрчлийн тухай хууль, MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Цахилгаан хангамжийн төв шугамд түр салгалт хийх үед ойр орчмын айл өрх, албан байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Цахилгааны байгууламжуудын холболт, угсралтын үед цахилгаан хангамжийн шугамд түр салгалт тохиолдол бүрт тухайн хэсгийн хорооны захиргаа, айл өрх албан байгууллагуудад 3 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэх арга хэмжээг авна Цахилгаан хангамжийн шугамд түр салгалт цагийг ажлын бус өдрүүдэд, оргил ачааллын цагаас зөрүүлэн хийхээр төлөвлөх 	ЧД-ийн 19-р хороо	Барилгын ажлын төсөвт багтсан					
Нийт дүн:						7,288,000		

6.2 DARI-2 гэрээний дугаар бүхий барилгын багц ажлын хүрээнд 2024 онд бүтээн байгуулах дэд бүтцийн байгууламжууд:

- ✚ Авто зам: 1526 м
- ✚ Дулаан дамжуулах шугам хоолой: 1141 м
- ✚ Цэвэр ус дамжуулах шугам хоолой: 1360 м
- ✚ Ариутгах татуургын шугам хоолой: 1214 м
- ✚ Дренажийн шугам хоолой: 522 м

Хүснэгт 6-2. DARI-2 багцын 2024 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажилд нийт 2.4 газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	<ul style="list-style-type: none"> ▪ Инженерийн шугам хоолой тавих ажилд өртөж эвдэрсэн 270 м² талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, нөхөн дүүргэлт, тэгшилгээний ажлууд хийж, анхны төрх байдалд нь оруулах буюу илүү сайжруулан хэлбэршүүлж, орчны тохижилт үүсгэх ▪ Станцын нийт талбайн 10% буюу 2400 м² талбайд ногоон байгууламж үүсгэн тохижуулж, мод зүлэг тарих 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт				Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Барилгын ажил дуусах үед	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм
Газар шорооны ажлаас 21000 м ³ хаягдал шороон материал үүсэх	<ul style="list-style-type: none"> ▪ 2089 м³ хэмжээтэй шороон материалыг шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглах ба үлдсэн 18,022 м³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Чингэлтэй дүүргийн хог тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. ▪ Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт				Барилгын ажлын төсөвт багтсан	Газар шорооны ажил явагдах хугацаанд, 7 хоног бүр	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	<ul style="list-style-type: none"> Хаягдал шороон материалыг их хэмжээний овоолго үүсгэж хуримтлуулалгүйгээр тухай бүрт нь Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулж байх Газар шорооны ажлаас үүсэх шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх 						Газар шорооны ажил явагдах хугацаанд	
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Усны хэмжээ м3	12961	3000 ²	2,888,000	Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношлогоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	Барилгын ажлын төсөвт багтсан				Барилгын ажлын туршид, 7 хоног бүр	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2000 Ажлын байрны
		Бүх тээврийн хэрэгсэл	ОХШХ-г тусган оруулсан				Барилгын ажлын туршид, Сар бүр	

² 6000 төг/м³- Гэр хорооллын бүсэд зөөврийн ус түгээх тариф

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
								орчин. Эрүүл ахуйн шаардлага
Барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас орчны агаарт тоосжилт үүсгэх	<ul style="list-style-type: none"> Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх Хүчтэй салхи шуургагай үед тоосжилтыг багасгах үүднээс хаягдал шороон материал ачих, барилгын материал буулгах зэрэг ажлыг түр зогсоох 	Барилгын ажлын талбай				Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажил, зам барилгын ажил, шугам хоолойн угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	<ul style="list-style-type: none"> Зам барилга ба барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд Барилгын ажлын талбай				Барилгын ажлын төсөвт багтсан ОХШХ-т тусган оруулсан	Барилгын ажлын туршид Сар бүр	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл
